

ДЭЛХИЙН ХҮН АМЫН ӨСӨЛТИЙН "ТЭСРЭЛТ"

Д.Тунгалаг *

Дэлхийн хүн ам тив, бүс нутаг, улс орнуудаар (тэр бүү хэл тухайн орны хувьд ч мөн адил) жигд бус тархсан байдаг. Орчин үеийн дэлхийн тулгамдсан чухал асуудлуудын нэг болоод байгаа хүн амын өсөлтийг харгалзахгүйгээр орчин үеийн дэлхийн нийгэм-эдийн засгийн аливаа судалгаа хийгдэхгүй нь тодорхой. Хүн амын өсөлтөөс шалтгаалан зарим улс орон, бүс нутагт ажиллах хүч дутагдах, улмаар гадны ажиллах хүчийг бөөнөөр нь оруулж ирэхэд хүргэдэг бол зарим улсад үндэсний эдийн засаг нь бүх хүмүүсийг ажлын байраар хангах боломжгүйгээс эсрэгээр хүн амын "илүүдэл" нь ажилгүйчүүдийн эгнээг огцом нэмэгдүүлэх хүндрэл учруулдаг гашуун туршлагыг хэн бүхэн илээхэн мэдэх билээ.

Өнөөдөр дэлхийн томоохон бүс нутаг, улс орнуудын хүн амын талаарх дүр зургийг дараах хүснэгтээс авч үзье.

Хүснэгт № 1

Дэлхийн томоохон бүс нутаг, улс орнуудын хүн амын тоо (хот, хөдөөгөөр, сая хүн)

Бүс нутаг, улсын нэр	Нийт хүн ам			Хотын хүн ам			Хөдөөгийн хүн ам		
	1975	1995	2015	1975	1995	2015	1975	1995	2015
1	2	3	4	5	6	7	8	9	10
Дэлхийн хүн ам	4077	5716	7469	1583	2584	4143	2539	3132	3326
Хөгжингүй бүс нутгууд	1044	1167	1224	729	874	991	315	293	233
Хөгжиж буй бүс нутгууд	3033	4550	6245	809	1710	3153	2224	2839	3090
Буурай хөгжилтэй бүс нутгууд	343	575	945	49	129	339	294	446	606
Африк	414	728	1204	104	250	568	310	478	636
Зүүн Африк	125	227	390	15	49	133	110	178	257
Төв Африк	45	82	146	12	27	68	33	55	78
Хойд Африк	96	161	232	37	74	133	59	87	99
Өмнөд Африк	29	47	71	13	23	43	16	25	28
Баруун Африк	118	211	364	27	77	190	91	134	174
Ази	2406	3458	4516	592	1198	2159	1814	2260	2357
Азийн хөгжиж буй орнууд	2294	3333	4390	508	1101	2055	1787	2232	2335

* МУИС, ОУХС-ийн профессор, доктор (Ph.D)

Зүүн Ази	1097	1424	1660	276	525	858	822	899	801
Хятад	928	1221	1441	160	369	676	768	852	765
Энэтхэг	-	935	1125	-	-	-	-	-	-
			0						
Япон	112	125	126	84	97	103	27	28	23
Өмнөд Азийн төв хэсэг	886	1381	1954	197	398	789	689	983	1165
Зүүн-Өмнөд Ази	324	484	645	72	163	313	252	321	332
Баруун Ази	99	181	183	132	146	155	38	35	28
Европ	676	727	726	454	535	582	223	192	145
Зүүн Европ	286	309	303	171	217	238	115	91	65
Хойд Европ	89	94	97	73	78	85	16	15	12
Өмнөд Европ	132	144	143	78	94	103	54	50	40
Баруун Европ	169	181	183	132	146	155	38	35	28
Латин Америк ба Карибын бассейн	320	482	641	196	358	526	124	124	115
Карибын бассейн	27	36	45	14	22	32	13	13	13
Төв Америк	78	126	176	45	86	134	34	40	42
Өмнөд Америк	214	320	420	138	249	360	77	70	60
Хойд Америк	239	293	345	177	223	282	63	69	62
Арлын орнууд	21	29	37	15	20	27	6	8	10
Австрали-Шинэ Зеланди	17	22	27	14	18	23	23	3	3

Тайлбар:

“Хөгжингүй бүс нутгууд” гэсэн бүлэгт бүх Европ, Хойд Америк, Австрали, Шинэ Зеландийн Япон улсууд хамрагдана. “Буурай хөгжилтэй бүс нутгууд” гэсэн бүлэгт “Хөгжиж буй бүс нутгууд” гэсэн бүлгээс бусад бүх улсууд хамрагдана.

Дээрх хүснэгтээс харахад:

- Сүүлийн 20 жил (1975-1995) дэлхийн хүн амын цэвэр өсөлт 1,7 тэрбум болж 2000 оны байдлаар дэлхийн нийт хүн амын тоо 6 тэрбум болоод байна.
- Эдийн засгийн хувьд хоцрогдмол бүс нутагт хүн амын бөөгнөрөл илүү ихээр явагдаж, харин өндөр хөгжилтэй орнуудад хүн ам сийрэг байгаа хандлага ажиглагдаж байгаа юм.
- Хүн ам хот, суурин газар луу илүү төвлөрч хөдөө орон нутагт амьдрах хүний тоо эрс багасч байна.

НҮБ-ын прогнозоор хүн амын өсөлтийн хурд цаашид удааширч, харин хүн амын нийт өсөлт 2015 он гэхэд бараг 2 тэрбумаар нэмэгдэх төлөвтэй байна. Өөрөөр хэлбэл 2015 онд дэлхийн хүн ам ойролцоогоор 7,5 тэрбум болно гэсэн үг. Дэлхийн эдийн засаг энэ тохиолдолд бүх хүн төрөлхтөнг бүрэн бүтэн амьдралаар хангаж чадах болов уу гэдэг асуудал өөрийн эрхгүй тулгарч байна.

Өндөр хөгжилтэй Европ, Хойд Америкийн улс орны хүн ам 1 тэрбум гаруй болж, харин бусад гурван тив – Ази, Африк, Латин Америкийн 150 орчим хөгжиж буй орнуудын хүн ам 5 тэрбум давж, түүний 2 тэрбум гаруй нь Хятад, Энэтхэг улсын хүн ам эзэлж байна. 2015 оны хүн амын прогнозоор хөгжиж буй орнуудын хотын хүн ам хөдөөгийн хүн амын тооны өсөлттэй харьцуулахад илүү хурдацтайгаар өсөх хандлага ажиглагдаж байна.

XX зууны нэрт судлаач-эдийн засагчдын нэг болох Р.Барр тухайн үедээ дэлхийн хүн амын тооны талаар судалгаа хийж дараах дүгнэлтийг гаргаж

байсан. Түүний хийсэн тооцоогоор дэлхийн хүн ам 1650 онд 500 сая байгаад 1900 он гэхэд 1,6 тэрбум, 1950 он гэхэд 2,5 тэрбум болсон гэсэн судалгаа байдаг. Тэгвэл өнөөдөр дэлхийн хүн ам 6 тэрбум болж, тэрбүү хэл 15 жилийн хугацаанд 1,5 тэрбумаар өсөх хандлагатай байгаа нь өөрийн эрхгүй анхаарал татах асуудал болоод байна.

Р.Барр “Аливаа нийгэм хүн амын хүчин зүйлийг хөдөлмөр болон үйлдвэрлэлд нөлөөлөх хамгийн үр ашигтай хүчин зүйл гэж тодорхойлдог” гэсэн санааг дэвшүүлж байв. Өндөр хөгжилтэй орнуудын аж үйлдвэрлэл 1800-1950 онд 100 дахин өссөн байдлыг Барр болон бусад эдийн засагчид энэ хугацаан дахь юуны өмнө хүн амын түргэн өсөлттэй уялдуулж тайлбарладаг. Өндөр хөгжилтэй орнуудын бүлэгт хамгийн их өсөлтийн хурд 1760-1860 онд болсон гэж тэмдэглэгдсэн бий. Тэр хугацаанд АНУ-ын хүн ам 3,5 дахин, Их Британийн хүн ам 2 дахин, Германы хүн ам 1,6 дахин, Францын хүн ам 1,4 дахин, Италийн хүн ам 1,2 дахин тус тус өссөн байдаг.

“Хүн амын өсөлтийн тэсрэлт”, “Хүн амын хувьсгал” гэсэн ойлголтууд өндөр хөгжилтэй орнуудын хүн амын талаарх судалгаанд огт хэрэглэгддэггүй байсан. Харин 1950-иад оны сүүлч, 1960-аад оны эхээр хүн амын өндөр өсөлтийн хурдыг (жил бүрийн цэвэр өсөлт 2 ба түүнээс дээш хувьтай) тодорхойлох үүднээс хөгжиж буй орнуудад анх хэрэглэгдэх болсон байна. Ийм хурдаар өсвөл хүн амын тоо 35 жил тутам 2 дахин өснө гэсэн үг юм.

XX зууны 50-60-аад онуудад хөгжиж буй орнуудад хүн амын дундаж наслалт харьцангуй нэмэгдэж эхэлсэн. Энэ нь аливаа өвчинг анагаах эм, био бэлдмэл бий болсонтой холбож тайлбарлаж болох юм.

1950-1980 онд хөгжиж буй орнуудын хүн амын цэвэр өсөлт дэлхийн аж үйлдвэржсэн орнуудынхаас (АНУ, Канад, Баруун Европын орнууд, Япон) бараг 6 дахин их байсан. Мөн тэр үед хүн амын өсөлтийн хурд Африкт – 2,9%, Баруун Азид 1980-аад онд 3,4%, 1990-ээд онд 2,6% байсан байна. Харин энэ үзүүлэлт АНУ-д 0,5%, Японд 0,1% тийм ч өндөр биш байв.

Үйлдвэр өндөр хөгжсөн орнуудын хүн ам зүйн шилжилт 1950-аад онд дуусч улмаар дундаж наслалт нэмэгдэн төрөлт багасч дэлхийн хүн амын материаллаг аж байдал сайжирсан юм. Үүний үр дүнд төрөлт ба нас баралтын муруй ойртож эдийн засгийн өсөлтийн нэг хүчин зүйл болох хүн ам зүйн динамик алдагдан хүн амын өсөлт удааших хандлагатай болсон.

Орчин үеийн хүн амын өсөлтийн “тэсрэлт”-ийн онцлог гэвэл:

- Хөгжиж буй орнуудын хүн амын өсөлт нь тэдгээрийн нийгэм-эдийн засгийн хөгжлөөс түрүүлж, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хангамж, хүнсний хангамж зэрэг тулгамдсан асуудлуудыг улам хүндрүүлж байна.
- Орчин үеийн хүн амын өсөлтийг өнгөрсөн XIX зуунд болсон хүн амын өсөлтийн “тэсрэлт”-тэй харьцуулахад хүч нь буурсан байдал ажиглагдаж байна.
- Өнөөдрийн дэлхийн хүн амын түргэн өсөлт маш өргөн хүрээ хамарснаараа онцлогтой.

Орчин үеийн хүн амын өсөлтийн “тэсрэлт” нь олон улс орон хийгээд дэлхийн хүн амын ихэнхийг хамарч байна. Одоо хүн амын өсөлтийн асуудал дэлхийн глобал тулгамдсан асуудлуудын нэг болоод байна.

Гэвч дэлхийн хүн амын өсөлт нь 1960-аад онд оргилдоо хүрч, 1980-аад оноос эхлэн буурах хандлагатай болсон. Одоо хүн амын өсөлтийн бууралт

дэлхийн бүх оронд ажиглагдаж, энэ нь өсөлтийн “тэсрэлт”-ийн дуусах үе шат гэж хэлж болохоор байгаа юм. Харин хүн амын “илүүдэл” нь Нигер, Конго, Ангол зэрэг зарим орнуудын хувьд өндөр байгаа бөгөөд буурах хандлага ажиглагдахгүй хэвээр байгаа юм.

Дэлхийн хүн амын үсрэнгүй өсөлтийн тухай яригдахад “хүн амын өөрчлөлт” гэсэн нэр томьёо зайлшгүй яригдах учиртай. “Хүн амын өөрчлөлт” нь төрөлт, нас баралтын өндөр үзүүлэлттэй уламжлалт нийгмийн хэлбэрээс орчин үеийн нийгэмд шилжих буюу төрөлт, нас баралтын түвшин буурч ердийн байдалд орохыг хэлнэ. Энэ нэр томьёог анх 1945 онд АНУ-ын хүн ам зүйч Фрэнк Ноутстэн бий болгож дэлхийн хоёрдугаар дайны дараа колоничлолын систем нурж хүн амын өөрчлөлт болоход өргөн хэрэглэгдэх болсон. Энэ үеэр өвчин тархалтыг зогсоосноор нас баралт эрс багасч төрөлт хурдацтай өсөх болсон нь хүн амын өсөлтийн “тэсрэлт”-эд хүргэсэн юм. Анх ийм өсөлт түүхэнд XIX зуунд ажиглагдаж байсан бөгөөд хүн амын төрөлт буурснаар тогтвортой байдалд хүргэж байсныг судлаачид тогтоосон. Хүн амын төрөлт, нас баралтын өндөр түвшин буурахыг хүн амын өөрчлөлт гэж нэрлэж, үүнийг дотор нь 4 үе шатаар ангилсан. Хөгжингүй орнууд ерөнхийдөө хүн амын өөрчлөлтийг дуусгаж, харин хөгжиж буй орнууд нь 2 дахь үе шатнаас гарч 3 дахь руу шилжих буюу “тэсрэлт”-ийн байдлаас гарч хүн амын өөрчлөлтийн үйл явцыг дуусгаж байна гэж үздэг.

Үйлдвэр өндөр хөгжсөн орнууд болон ОХУ, БНХАУ зэрэг орнууд хүн амын өөрчлөлтийн үйл явцыг дуусгасан. Харин хүн амын төрөлт эрс багассан орнуудын тоонд Египет, Алжир, Мексик, Бразил, Аргентин болон Латин Америкийн зарим орнууд орно.

Иран, Турк, Тунис зэрэг оронд төрөлт нь ердийн байдалд хүрсэн. Харин 1970 онд төрөлт нь хэвийн түвшинд хүрэхгүй байгаа орнууд нийт 13 байсан бол 2002 онд эрс нэмэгдэж 66 хүрсэн байх жишээтэй. Эдгээр орнуудын хүн ам дэлхийн нийт хүн амын 46%-ийг эзэлж байсан.

Хөгжиж буй орнуудын нийгэм-эдийн засгийн нөхцөл, гэр бүлийн уламжлалт хэлбэрийн өөрчлөлт, эмэгтэй хүний статус дээшилснээр төрөлт эрс багассан. Үүний зэрэгцээ нас баралт буурч хүн ам залуужиж эхэлсэн. Үүнийг судлаачид тайлбарлахдаа орчин үеийн хүн амын өсөлтийн “тэсрэлт” хадгалагдаж байна гэж үздэг. Хөгжил буурай орнуудад хүүхдийн нас баралттай тэмцэж байгаа нь тийм ч амжилттай биш бөгөөд Африкийн орнуудад ДОХ өвчний улмаас нас баралтын түвшин өндөр хэвээр байгаа юм.

БНХАУ, Энэтхэг зэрэг орнуудад нэлээд хатуу гэж хэлж болохоор хүн амын төрөлтийг хязгаарлах бодлого явуулж байгаа хэдий ч дэлхийн хүн амын өндөр өсөлтийн “тэсрэлт”-ийн асуудал өнөөдрийн тулгамдсан асуудлын нэг хэвээр байна.